



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХАРАА-ЕРӨӨ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ 2024 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2025/24/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор Н.Хулансүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: Khulansurenn@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2025 он

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	16
3.5.3 Нэмэлт төсөв.....	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	17
3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	17
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага.....	19
5.3 Зөвлөмж.....	19

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БОУАӨС	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.18 № 40

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хараа-Ерөө голын сав газрын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хараа-Ерөө голын сав газрын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас үнэ төлбөргүй шилжүүлсэн 1,267.9 мянган төгрөгийн санхүүгийн программыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 802 дугаар тогтоолоор биет бус хөрөнгөөр бүртгэж, толилуулсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу төрийн захиргааны албан хаагчдад 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож эхэлснээр энэ зардалд нийт 15,435.0 мянган төгрөг төлөвлөж зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг 80.1 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4525020042

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.МӨНХБАЯР



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>10,211,750.00</u>	<u>16,573,250.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	8,143,500.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	8,143,500.00
3121	Төгрөг	-	8,143,500.00
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	-	8,143,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>10,211,750.00</u>	<u>8,429,750.00</u>
354	Хангамжийн материал	10,211,750.00	8,429,750.00
35410	Бичиг хэргийн материал	826,050.00	601,500.00
35420	Аж ахуйн материал	1,547,700.00	391,250.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,615,000.00	5,615,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,223,000.00	1,822,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>367,089,127.49</u>	<u>271,238,506.60</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	367,089,127.49	271,238,506.60
392	Биет хөрөнгө	329,589,127.49	232,470,573.27
39203	Авто-тээврийн хэрэгсэл	315,446,996.50	315,446,996.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,963,166.65)	(110,182,040.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,944,956.56	56,013,256.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13,273,148.03)	(28,807,639.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,449,628.26	11,449,628.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,016,139.15)	(11,449,628.18)
393	Биет бус хөрөнгө	37,500,000.00	38,767,933.33
39301	Программ хангамж	330,000.00	1,267,933.33
39302	Хуримтлагдсан элэгдэл	(330,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	37,500,000.00	37,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>377,300,877.49</u>	<u>287,811,756.60</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>377,300,877.49</u>	<u>287,811,756.60</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	377,300,877.49	287,811,756.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	37,500,000.00	37,500,000.00
51101	Өмч: - төрийн	37,500,000.00	37,500,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	339,800,877.49	250,311,756.60
51210	Өмнөх үеийн үр дүн	339,800,877.49	302,916,502.98
51220	Тайлант үеийн үр дүн	-	(52,604,746.38)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>377,300,877.49</u>	<u>287,811,756.60</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	585,015,963.30	402,739,049.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	301,426,096.50	20,460,149.33
120	Нийтлэг татварын бус орлого	301,426,096.50	20,460,149.33
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	301,426,096.50	12,316,649.33
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	301,226,096.50	11,816,649.33
120009	Бусад орлого	-	8,143,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	283,589,866.80	382,278,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	249,627,500.00	353,187,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	249,627,500.00	353,187,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,962,366.80	29,091,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,462,366.80	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00	11,228,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,700,000.00	17,863,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	301,632,322.57	455,343,795.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	301,632,322.57	455,343,795.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	263,853,853.97	371,686,158.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,146,519.92	224,044,088.93
210101	Үндсэн цалин	118,260,668.52	146,910,172.41
210102	Нэмэгдэл	39,973,499.80	48,564,416.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,571,000.00	13,334,000.00
210104	Урамшуулал	12,341,351.60	15,235,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,568,198.28	26,671,763.65
210201	Тэтгэврийн даатгал	15,485,006.75	18,351,550.07
210202	Тэтгэмжийн даатгал	1,821,765.52	2,089,565.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,457,412.41	1,044,782.95
210204	Ажилгүйдлийн даатгал	345,819.44	1,009,396.96
210205	Эрүүл мэндийн даатгал	3,458,194.16	4,176,467.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,986,800.00	11,909,800.00
210301	Гэрэл, цахилгаан	720,000.00	720,000.00
210304	Байрны түрээс	10,266,800.00	11,189,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,736,620.00	12,328,536.00
210401	Бичиг хэрэг	1,414,580.00	985,166.00
210402	Тээвэр, шатахуун	9,700,000.00	7,650,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	940,640.00	1,146,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,681,400.00	2,546,920.00
2105	Нормативт зардал	2,827,100.00	868,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,827,100.00	868,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,465,300.00	228,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	228,000.00
210604	Урсгал засвар	1,465,300.00	-
2107	Томилолт, зочны зардал	8,246,000.00	24,150,000.00
210702	Дотоод албан томилолт	8,246,000.00	24,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,480,360.00	836,290.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,925,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	258,930.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	328,360.00	328,360.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	194,000.00	194,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,396,955.77	70,649,679.71
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	347,200.00	347,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,049,755.77	70,302,479.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,778,468.60	83,657,637.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	19,355,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,920,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	15,435,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,778,467.72	64,253,836.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,778,467.72	64,253,836.99
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.88	48,800.43
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.88	48,800.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	283,383,640.73	(52,604,746.38)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	283,383,640.73	(52,604,746.38)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	283,789,866.80	390,922,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	200,000.00	8,643,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	200,000.00	8,643,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,000.00	500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	500,000.00
120009	Бусад орлого	-	8,143,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	283,589,866.80	382,278,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	249,627,500.00	353,187,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	249,627,500.00	353,187,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,962,366.80	29,091,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,462,366.80	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00	11,228,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,700,000.00	17,863,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	282,821,666.80	382,778,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	282,821,666.80	382,778,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	245,043,198.20	299,121,262.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,176,548.95	224,044,088.93
210101	Үндсэн цалин	117,486,171.87	146,910,172.41
210102	Нэмэгдэл	40,778,025.48	48,564,416.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,571,000.00	13,334,000.00
210104	Урамшуулал	12,341,351.60	15,235,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,538,169.25	26,671,763.65
210201	Тэтгэврийн даатгал	15,552,784.84	18,351,550.07
210202	Тэтгэмжийн даатгал	1,804,820.99	2,089,565.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,443,856.80	1,044,782.95
210204	Ажилгүйдлийн даатгал	342,430.54	1,009,396.96
210205	Эрүүл мэндийн даатгал	3,394,276.08	4,176,467.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,986,800.00	11,909,800.00
210301	Гэрэл, цахилгаан	720,000.00	720,000.00
210304	Байрны түрээс	10,266,800.00	11,189,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,196,120.00	10,146,120.00
210401	Бичиг хэрэг	1,424,180.00	985,166.00
210402	Тээвэр, шатахуун	9,503,800.00	7,420,834.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,026,240.00	1,060,850.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,241,900.00	679,270.00
2105	Нормативт зардал	572,000.00	588,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	572,000.00	588,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500,000.00	428,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	428,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	8,246,000.00	24,150,000.00
210702	Дотоод албан томилолт	8,246,000.00	24,150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,480,360.00	836,290.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,925,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	258,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	328,360.00	328,360.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	194,000.00	194,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	347,200.00	347,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	347,200.00	347,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,778,468.60	83,657,637.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	19,355,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,920,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	15,435,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,778,467.72	64,253,836.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,778,467.72	64,253,836.99
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.88	48,800.43
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.88	48,800.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>968,200.00</u>	<u>8,143,500.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	968,200.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	968,200.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	968,200.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	968,200.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(968,200.00)</u>	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	8,143,500.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	8,143,500.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	37,500,000.00	-	56,417,236.76	-	93,917,236.76
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,500,000.00	-	56,417,236.76	-	93,917,236.76
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	283,383,640.73	-	283,383,640.73
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,500,000.00	-	339,800,877.49	-	377,300,877.49
D01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	37,500,000.00	-	339,800,877.49	-	377,300,877.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(36,884,374.51)	-	(36,884,374.51)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37,500,000.00	-	302,916,502.98	-	340,416,502.98
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(52,604,746.38)	-	(52,604,746.38)
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	37,500,000.00	-	250,311,756.60	-	287,811,756.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	353,187,400.00	289,433,563.01	(63,753,836.99)	81.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	353,187,400.00	289,433,563.01	(63,753,836.99)	81.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	337,752,400.00	273,998,563.01	(63,753,836.99)	81.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,451,100.00	217,097,689.32	(54,353,410.68)	80.0
210101	Үндсэн цалин	149,207,900.00	146,910,172.41	(2,297,727.59)	98.5
210102	Нэмэгдэл	61,966,200.00	41,618,016.91	(20,348,183.09)	67.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,171,300.00	13,334,000.00	(25,837,300.00)	34.0
210104	Урамшуулал	21,105,700.00	15,235,500.00	(5,870,200.00)	72.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,169,700.00	25,803,463.69	(9,366,236.31)	73.4
210201	Тэтгэврийн даатгал	23,915,400.00	17,761,106.10	(6,154,293.90)	74.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,813,600.00	2,020,101.90	(793,498.10)	71.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,406,800.00	1,010,050.95	(396,749.05)	71.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,406,800.00	974,664.96	(432,135.04)	69.3
210205	Эрүүл мэндийн даатгал	5,627,100.00	4,037,539.78	(1,589,560.22)	71.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,909,800.00	11,909,800.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	720,000.00	720,000.00	-	100.0
210304	Байрны түрээс	11,189,800.00	11,189,800.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,169,800.00	6,166,120.00	(3,680.00)	99.9
210401	Бичиг хэрэг	526,000.00	526,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	3,900,000.00	3,900,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,063,300.00	1,060,850.00	(2,450.00)	99.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	680,500.00	679,270.00	(1,230.00)	99.8
2105	Нормативт зардал	588,100.00	588,000.00	(100.00)	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	588,100.00	588,000.00	(100.00)	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	428,300.00	428,000.00	(300.00)	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	428,300.00	428,000.00	(300.00)	99.9
2107	Томилолт, зочны зардал	10,851,900.00	10,822,000.00	(29,900.00)	99.7
210702	Дотоод албан томилолт	10,851,900.00	10,822,000.00	(29,900.00)	99.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	836,500.00	836,290.00	(210.00)	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	259,000.00	258,930.00	(70.00)	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	328,500.00	328,360.00	(140.00)	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	194,000.00	194,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	347,200.00	347,200.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	347,200.00	347,200.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,435,000.00	15,435,000.00	-	100.0

2132	Бусад урсгал шилжүүлэг	15,435,000.00	15,435,000.00	-	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,435,000.00	15,435,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	353,187,400.00	289,433,563.01	(63,253,836.99)	82.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	353,187,400.00	289,433,563.01	(63,753,836.99)	81.9
131001	Улсын төсвөөс санхүүжих	353,187,400.00	289,433,563.01	(63,753,836.99)	81.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	500,000.00	500,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	500,000.00	500,000.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		8,143,500.00	8,143,500.00	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11.00	8.00	(3.00)	72.7
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	6.00	(3.00)	66.7
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	11.00	8.00	(3.00)	72.7
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	6.00	(3.00)	66.7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2.00	2.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,091,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,091,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,122,699.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,946,399.61
210102	Нэмэгдэл	6,946,399.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	868,299.96
210201	Тэтгэврийн даатгал	590,443.97
210202	Тэтгэмжийн даатгал	69,464.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	34,732.00
210204	Ажилгүйдлийн даатгал	34,732.00
210205	Эрүүл мэндийн даатгал	138,927.99
2104	Хангамж, бараа материалын зардал	3,980,000.00
210401	Бичиг хэрэг	459,166.00
210402	Тээвэр, шатахуун	3,520,834.00
2107	Томилолт, зочны зардал	13,328,000.00
210702	Дотоод албан томилолт	13,328,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,920,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,920,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,920,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	48,800.43
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	48,800.43
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	29,091,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,091,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,228,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,863,500.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хараа-Ерөө голын сав газрын захиргаа нь сав газрын усны нөөцийг хамгаалах боломжит нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, усны нөөцийн менежментийг боловсруулж хэрэгжүүлэх, салбар дундын зохицуулалтыг хангах чиг үүрэгтэй, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь 2024 онд “Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах ажлын уялдаа холбоог хангах, төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэн, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүнд сурталгүй, хүртээмжтэй, ил тод, хялбар хүргэх, усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэх, усны нөөцийг зохистой ашиглах усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлэх, зохицуулах, мэргэжил арга зүйгээр хангах, хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах бодлогыг дэмжих үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэх” гэсэн зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон холбогдох дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хараа-Ерөө голын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/641 дугаар тушаалаар баталж, мөрдөж эхэлсэн байна. Тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж,

нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хараа-Ерөө голын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 287,811.8 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	8,143.5	8,143.5
Авлага	-	-	-
Бараа материал	10,211.8	8,429.8	(1,782.0)
Үндсэн хөрөнгө	367,089.1	271,238.5	(95,850.6)
Нийт хөрөнгө	377,300.9	287,811.8	(89,489.1)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	377,300.9	287,811.8	(89,489.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	377,300.9	287,811.8	(89,489.1)

Мөнгөн хөрөнгийн дансны 8,143.5 мянган төгрөгийн үлдэгдэл нь ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл бөгөөд тайлант хугацаанд цалингийн сангийн 3 хувиар тооцон 8,143.5 мянган төгрөг цалингийн зардлаас төвлөрүүлж, зарцуулаагүй байна.

Бараа материалын дансны хувьд БОАЖЯамнаас 251.3 мянган төгрөгийн лац тороос, 229.2 мянган төгрөгийн түлш, шатах тослох материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 10,548.5 мянган төгрөгийн материал бэлтгэж, 12,810.9 мянган төгрөгийн материал зарцуулснаар оны эцэст 8,429.8 мянган төгрөгийн үлдэгдэл тайлагнасан байна. Үүнд сэлбэр хэрэгсэл болон бусад хангамжийн материалын үлдэгдэл нийт бараа материалын 88.2 хувийг эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 95,850.6 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2024 оны А-1/1868 дугаар тогтоолоор 10,068.3 мянган төгрөгийн компьютер, 802 дугаар тогтоолоор 1,267.9 мянган төгрөгийн санхүүгийн программ орлогод хүлээн авч, 818 дугаар тогтоолоор 330.0 мянган төгрөгийн үнэтэй санхүүгийн программ данснаас хасаж, тайлант онд 107,186.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо 287,811.8 мянган төгрөг болж, 89,489.1 мянган төгрөгөөр буурсан нь аудитаар өмнөх оны 36,884.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсон, тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 2023 оны 03 дугаар сард 286,273.3 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Дээд шатны төсвийн захирагч төсвийн саналыг нийт 44,803.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 331,077.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин хөлс болон НДШ-ийн зардлыг 89,659.5 мянган төгрөгөөр нэмж, бараа материал, эд хогшил урсгал засварын зардал, нормативт зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг нийт 44,855.7 мянган төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 22,110.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 353,187.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2024 онд байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа материал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлыг 22,631.8 мянган төгрөгөөр нэмж, эд хогшил, урсгал засварын зардлыг 521.5 мянган төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэх 353,187.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс авсан 353,187.4 мянган төгрөгийн санхүүжилтээс 289,433.6 мянган төгрөгийг зарцуулж, санхүүжилтээс үлдсэн 63,753.8 мянган төгрөгийг төлөвлөөгүй орлого 500.0 мянган төгрөгийн хамт улсын төсөвт төвлөрүүлсэн. Энэ нь тайлант онд орон тоо дутуу ажилласнаар цалин хөлс болон НДШ-ийн 63,719.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолтын зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлыг 34.2 мянган төгрөг тус тус зарцуулаагүй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
1	71404-Хараа-Ерөө голын сав газрын захиргаа	353,187.4	289,433.6	63,753.8	81.9
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	337,752.4	273,998.6	63,753.8	81.1
1.2	80802-Ажил олгогчоор олгох тэтгэмж	15,435.0	15,435.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэгдсэн судалгааны дүнгээр тус газар нь БОАЖ-ын сайдын 2018 оны А/158, 2022 оны А/335 дугаар тушаалуудаар 11 орон тоо баталснаас гүйцэтгэлээр 8 албан хаагч ажилласан байна.

Тайлант онд Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу цалингийн сангийн 3 хувиар 8,143.5 мянган төгрөг ахмадын санд төвлөрүүлснээс тайлант онд зарцуулаагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 54 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн нэмэгдэл зардалд 7,863.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулаагүй үлдсэн 48.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраас Дэлхийн усны өдрийн үйл ажиллагаанд оролцсон албан хаагчдын томилолтын зардалд 2,308.0 мянган төгрөг, цөөрөм байгуулах боломжит газрын байршлыг сонгон тодорхойлох ажлын санхүүжилт

5,000.0 мянган төгрөг, Төв аймгийн Засаг дарга, БОАЖГ-аас тус аймгийн сумдад усны тоо бүртгэл хийх ажлын санхүүжилт 10,000.0 мянган төгрөг, БОУАӨ-ийн сайдын 2024 оны “Улсын төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны давсан орлого хуваарилах тухай” А/885 тушаалын дагуу давсан орлого 3,920.0 мянган төгрөгийг 100 хувь зарцуулж тайлагнасан байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хараа-Ерөө голын сав газрын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газрын аудитор Н.Хулансүрэн гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хараа-Ерөө голын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 353,187.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,531.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д заасны дагуу томилолт, зочны зардлыг 29.9 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг бүрэн оруулж, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус газрын өмнөх оны аудитаар 2,448.2 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн биелэлтийг шалгахад 100 хэрэгжүүлж ажилласан байна

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	2,448.2	1	2,448.2	100.00
Нийт дүн	1	2,448.2	1	2,448.2	100.00

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар өнгөрсөн онд шинээр бүртгэсэн үндсэн хөрөнгийн орлогод авсан хугацааг үнэн зөв оруулаагүйгээс хуримтлагдсан элэгдэл 36,884.4 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд ахмадын санд төвлөрүүлсэн 8,143.5 мянган төгрөгийг буруу дансанд бүртгэсэн зэрэг нийт 45,027.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4, 8 дугаар зүйлийн 8.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсэг, санхүүгийн тайлангийн аудитын “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг нэмэгдүүлж, ахмадын санд төвлөрүүлсэн хөрөнгийг бусад орлого дансанд бүртгэж залруулав.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход анх ашиглалтад орсон огноог буруу оруулснаар 36,884.4 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг дутуу байгуулсан зөрчил илэрлээ.	1	36,884.4	1	36,884.4	-	-	1	36,884.4	-	-	-	-
Мөнгөн гүйлгээний тайланд Ахмадын сангийн 8,143.5 мянган төгрөгийн гүйлгээг эдийн засгийн ангилал хэсгийг нэмэлт санхүүжилтийн зардал холбож, буруу бүртгэсэн зөрчил илэрлээ.	1	8,143.5	-	-	1	8,143.5	1	8,143.5	-	-	-	-
Дүн	2	45,027.9	1	36,884.4	1	8,143.5	2	45,027.9	-	-	-	-